



# 2022 оны I улирлын санхүү, үйл ажиллагааны тайлан



"ЛэндМН ББСБ" ХК

# Агуулга

“ЛэндМН ББСБ” ХК-ийн 2022 оны I улирлын санхүү, үйл ажиллагааны тайлан

• Зээлийн үйл ажиллагаа	06	Зээлийн үйл ажиллагаа
	08	Зээлийн багцын чанарын үзүүлэлтүүд
• Бизнесийн үйл ажиллагаа	10	Бизнесийн үйл ажиллагаа
• Харилцагчийн үйл ажиллагаа	22	Харилцагчийн үйл ажиллагаа
• Санхүүгийн үйл ажиллагаа	24	Санхүүгийн үйл ажиллагаа
	25	Санхүүгийн байдлын хураангуй тайлан
	26	Орлого, үр дүнгийн хураангуй тайлан
• Эрсдэлийн удирдлага	28	Эрсдэлийн удирдлага
	29	Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд
• Компанийн засаглал	30	Компанийн засаглал
	30	Төлөөлөн удирдах зөвлөл
	31	ТУЗ-ийн дэргэдэх засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороо



## Гүйцэтгэх захирлын мэндчилгээ



**Дижитал хөрөнгө оруулалт “Лэндбонд”-ыг 3 дахь удаагаа хөтөлбөртэйгөөр гаргаж 2 транчаар нийт 5.6 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүллээ.**

Сайн байцгаана уу, эрхэм хүндэт хөрөнгө оруулагчид, хувьцаа эзэмшигчид, хамтрагч байгууллагууд, харилцагчид та бүхнийхээ энэ өдрийн амар амгаланг эрэн мэндчилж байна. (Ковид-19) цар тахалтай холбоотойгоор хөрөнгө оруулагчид, хувьцаа эзэмшигчдээ эрсдэлээс сэргийлэх зорилгоор “ЛэндМН ББСБ” ХК техник технологийн шийдлийг ашиглан Хувьцаа

эзэмшигчдийн ээлжит хурлаа 2022 оны 03-р сарын 26-ны өдөр “ЦАХИМ ХЭЛБЭР”-ээр 3 дахь жилдээ амжилттай зохион байгуулаа. Энэ нь Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй нийт хувьцаат компаниудаас 3 жил дараалан тухайн жилийнхээ хамгийн анхны цахим Хувьцаа эзэмшигчдийнхээ хурлыг хийсэн тохиолдол болсноороо онцлогтой байлаа.

2021 онд компанийн цэвэр зээлийн багц 28%-иар өсөж, компанийн цэвэр ашиг 4 тэрбум төгрөгт хүрсэн байна. Энэ нь цэвэр ашиг (Ковид-19)-ийн өмнөх үеийн түвшинд хүрч бизнес сэргэж байгааг харуулсан үзүүлэлт болжээ. 2021 оны цэвэр ашиг зорилтот түвшинд хүрсэн тул компанийн ТУЗ-ийн шийдвэрийн дагуу “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2021 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 1.5 төгрөг буюу нийт 1,108,952,525.50 төгрөгийн ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдэдээ мөнгөн хэлбэрээр хуваарилахаар боллоо. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг 2022 оны 02 сарын 25-ны өдрөөр тасалбар болгон гаргаж, 2022 оны 04 сарын 30-ны өдрийн дотор “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ТӨХХК-аар дамжуулан хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулан олгохоор шийдвэрлэлээ.

**Дижитал хөрөнгө оруулалт “Лэндбонд”-ыг 3 дахь удаагаа хөтөлбөртэйгөөр гаргаж 2 транчаар нийт 5.6 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүллээ.**

2021 оны 11 сарын 29-ний өдөр “Лэндбонд”-ын Транч I-ийн захиалга явагдаж нийт 44 хөрөнгө оруулагчаас 2.5 тэрбум төгрөгийн захиалга хүлээн авснаар анхдагч зах зээлийн захиалга 100%-тай биелсэн бол “ЛэндБонд”-ын Транч II-ын

анхдагч зах зээлийн арилжаа 2022 оны 03 дугаар сарын 28-ны өдрөөс 03 дугаар сарын 31-ний өдрүүдэд зохион байгуулагдаж нийт 188 хөрөнгө оруулагчдаас 3.1 тэрбум төгрөгийг арилжаа зарлагдсан хугацаанаас өмнө татан төвлөрүүлж, анхдагч зах зээлийн арилжаа амжилттай хаагдлаа. “ЛэндБонд” Транч II-ийн хүүгийн хэмжээг 15% болгон нэмэгдүүлсэн нь энэ удаагийн Транчийн онцлог байж, олон нийтийн анхаарлыг ихээр татсан үйл явдал боллоо.

“ЛэндМН ББСБ” ХК нь Дижитал хөрөнгө оруулалт “ЛэндБонд” Транч I болон II-ийн анхдагч зах зээлийн захиалгыг LendMN аппликэйшнээр дамжуулан авах боломжийг хөрөнгө оруулагчдад олгосноор хөрөнгийн зах зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулагчдыг үнэт цаасны зах зээлийн арилжаанд идэвхтэй оролцох боломжуудыг бий болгосноороо давуу талтай байлаа.

Цаашид бизнесийн урт хугацааны тогтвортой өсөлтийг хангах, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг бий болгох, байгууллагын хөгжлийг шинэ шатанд гаргах тал дээр хүчин чармайлт гарган ажиллаж байна.

“ЛэндМН ББСБ” ХК нь нийт харилцагч, хувьцаа эзэмшигч та бүхэндээ 2022 оны I улирлын санхүү, үйл ажиллагааны тайлангаа танилцуулж байна ■

*Хүндэтгэсэн: “ЛэндМН ББСБ” ХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Угвал*

Бизнесийн үйл ажиллагаа


# Зээлийн үйл ажиллагаа



2022 оны I улиралд нийт харилцагчдаа 55.5 тэрбум төгрөгийн дүнтэй 266.6 мянган зээлийг LendMN аппликэйшнээр дамжуулан олгосон байна. Түүнчлэн 2022 оны I улирлын зээлийн голлох үзүүлэлтүүдийг

2021 оны IV улиралтай харьцуулахад гэрээт харилцагчдын тоо 2.9%, олгосон зээлийн тоо 6.9%, цэвэр зээлийн багц 4%-иар тус тус өссөн амжилттайгаар бид 2022 оны I улирлаа үдлээ.


**Гэрээт харилцагчийн тоо**  
/Өссөн дүнгээр, мянган харилцагчид/



**Нийт олгосон болон сунгасан зээлийн тоо**  
/мянган зээл/



**Нийт олгосон болон сунгасан зээлийн дүн**  
/тэрбум төгрөг/



**Цэвэр зээлийн багц**  
/тэрбум төгрөг/



# Зээлийн багцын чанарын үзүүлэлтүүд

2022 оны I улирлын байдлаар чанаргүй зээлийн багцад эзлэх хувь 6.5% байгаа бөгөөд энэ улиралд зээлийн эрсдэлийн сангийн нөөц 2.53 тэрбум

төгрөг буюу зээлийн эрсдэлийн сангийн хүрэлцээ 109.05% байна

Тэрбум төгрөг	2021.III	2021.IV	2022.I
<b>Нийт зээлийн багц</b>	<b>33.03</b>	<b>34.62</b>	<b>35.50</b>
Зээлийн эрсдэлийн сан	(2.87)	(2.20)	(2.53)
<b>Цэвэр зээлийн багц</b>	<b>30.16</b>	<b>32.42</b>	<b>32.97</b>
Хэвийн зээл	29.80	32.19	32.13
Хугацаа хэтэрсэн зээл	0.94	0.68	1.05
Чанаргүй зээл	2.30	1.75	2.32
Чанаргүй зээлийн багцад эзлэх хувь	6.7%	5.0%	6.5%
Эрсдэлийн сангийн хүрэлцээ	124.9%	125.5%	109.1%



## Бизнесийн үйл ажиллагаа


Бизнесийн үйл ажиллагаа

### ЛЭНДМН ББСБ" ХК 1.1 тэрбум төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар боллоо

"ЛэндМН ББСБ" ХК ("Компани" гэх) нь 2021 онд (Ковид-19) цар тахлаас үүдэлтэй нийгэм эдийн засгийн тодорхойгүй нөхцөл байдалд оновчтой шийдвэрийг тухай бүр гаргаж, хөрөнгө оруулагч,

хувьцаа эзэмшигчдэдээ ногдол ашиг хуваарилах шийдвэр гаргалаа.

Компанийн ТУЗ-ийн шийдвэрийн дагуу "ЛэндМН ББСБ" ХК-ийн 2021 оны цэвэр ашгаас нэгж



хувьцаа эзэмшигчийн эрсдэлийг хамгийн бага түвшинд байлгах, харилцагч нартаа уян хатан, боломжит нөхцөлийг санал болгох, системийн шинэчлэлтийг хийж, шинэ бүтээгдэхүүн гаргах дэд бүтцийг бий болгох, бизнесийг өсөлтийг хангах зэрэг шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлж ажиллалаа.


Ингэснээр 2021 онд цэвэр зээлийн багц 28%-иар өсөж, компанийн цэвэр ашиг 4 тэрбум төгрөгт хүрсэн байна. Энэ нь цэвэр ашиг (Ковид-19)-ийн өмнөх үеийн түвшинд хүрч бизнес сэргэж байгааг харуулсан үзүүлэлт болжээ. 2021 оны цэвэр ашиг зорилтот түвшинд хүрсэн тул Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ" гэх) нь 2022 оны 02 сарын 07-ны өдрийн ээлжит хурлаар

хувьцаанд 1.5 төгрөг буюу нийт 1,108,952,525.50 төгрөгийн ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдэдээ мөнгөн хэлбэрээр хуваарилахаар болсон байна. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг 2022 оны 02 сарын 25-ны өдрөөр тасалбар болгон гаргаж, 2022 оны 04 сарын 30-ны өдрийн дотор "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ТӨХХК-аар дамжуулан хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулан олгохоор шийдвэрлэв.

Цаашид бизнесийн урт хугацааны тогтвортой өсөлтийг хангах, дэлхийд өрсөлдөх бүтээгдэхүүн үйлчилгээг бий болгох, байгууллагын хөгжлийг шинэ шатанд гаргах тал дээр хүчин чармайлт гарган ажиллаж байна.

Бизнесийн үйл ажиллагаа

## “ЛэндМН ББСБ” ХК хувьцааны ханшийн мэдээлэл



Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

2022 оны 3 дугаар сарын 31-ний өдөр Монголын Хөрөнгийн Биржийн I ангилалд 18 компанийн 218,218 ширхэг хувьцаа арилжигдсанаас “ЛэндМН ББСБ” ХК-ийн 11,901 ширхэг хувьцаа арилжигдсан бөгөөд 2022 оны I улирлын хаалтын байдлаар компанийн нэгж хувьцааны ханш 38.9 төгрөгт хүрч, 35.3%-иар өссөн үзүүлэлттэй байна.

### 2022.I улиралд:

Нийт арилжаалагдсан ширхэг - 3.25 сая ширхэг  
Нийт арилжаалагдсан үнийн дүн - 137.37 сая төгрөг

Хувьцаа эзэмшигчдийн эзлэх хувь



Бизнесийн үйл ажиллагаа

## LendMN аппликейшний бүтээгдэхүүн үйлчилгээний төрөл нэмэгдэж “Хөрөнгө оруулалт” цэстэй боллоо

### “Хөрөнгө оруулалт” цэсний тухай

Харилцагч та бүхэн хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн үйлчилгээтэй “Хөрөнгө оруулалт” цэс рүү орж танилцан найдвартай, баталгаатай дижитал хөрөнгө оруулалтын үйлчилгээнүүдээс өөрт тохирохыг сонгон ашиглаарай.

### Санхүүгээ зөв удирдъя

### Lendplus - Боломжоо нээ


Санхүүгийн хэрэгцээгээ зөвөөр удирдах, мөнгөн хөрөнгөө эрсдэлгүй өөртөө ажиллуулах боломжтой итгэлцлийн үйлчилгээ юм.

### Lendbond - Дижитал хөрөнгө оруулалт

Өгөөж өндөртэй, тогтмол хүүгийн орлого хүртэх боломжтой, баталгаатай, захиалахад хялбар, хүссэн үедээ худалдах боломжтой нээлттэй бонд юм.

### Lend итгэлцэл - Шинэ боломж

Хөрөнгөө үнэгүйдэхээс хамгаалах санхүүгийн хэрэгсэл болох итгэлцлийн үйлчилгээ юм.






оролцож компанийн үйл ажиллагаатай холбоотой дараах асуудлуудыг хэлэлцэн баталлаа. Үүнд:

- Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайланг танилцуулах;
- Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэн батлах;
- Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2021 оны үйл ажиллагааны тайланг танилцуулах;
- Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 5 гишүүдийг улируулан сонгох;
- Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 4 гишүүдийг шинээр сонгох;
- Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны төсвийг батлах;

“ЛэндМН ББСБ” ХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Удвал компанийн өнгөрсөн оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулан, “ЛэндМН ББСБ” ХК-ийн ТУЗ-ийн 2022 оны 2 дугаар сарын 07-ны өдрийн ээлжит хурлаар 2021 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 1.5 төгрөг буюу нийт 1,108,952,525.50 төгрөгийн ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдэдээ мөнгөн хэлбэрээр хуваарилахаар шийдвэрлэсэн талаар мэдээллээ. Ногдол ашиг авах хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг 2022 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн дотор “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ТӨХХК-аар дамжуулан хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулах юм байна.

Харин “ЛэндМН ББСБ” ХК-ийн ТУЗ-ийн дарга О.Болдбаатар 2021 оны үйл ажиллагаа



Бизнесийн үйл ажиллагаа

## “ЛэндМН ББСБ” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал цахим хэлбэрээр 3 дахь жилдээ амжилттай зохион байгуулагдлаа

“ЛэндМН ББСБ” ХК 2022 оны 3 дугаар сарын 26-ны өдөр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа цахим хэлбэрээр зохион байгуулаа. Тус компани нь гурав дахь жилдээ цахим хэлбэрээр хийгдэж буй энэхүү хурал нийт хувьцаа эзэмшигчдэдээ эрсдэл учруулахгүйгээр, COVID-19 цар тахлын

халдвараас сэргийлэх зорилгоор, халдвар хамгааллын дэглэмийг чанд баримтлан зохион байгуулаа.

Хурлыг компанийн фэйсбүүк пэйж хуудсаар шууд дамжуулан үзүүлсэн бөгөөд энэхүү хуралд нийт саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 84.28% нь

болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг танилцуулсан бөгөөд 2021 оны ТУЗ-ийн үйл ажиллагааны тайлан мөн ТУЗ-д ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшигчдийг зарлаж танилцуулаа.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дарга “ЭмДиЭс энд ХаанЛекс” ХХН-ийн партнер С.Батбуян “ Хувьцаа эзэмшигчид урьдчилан хүлээн авсан нэвтрэх нэр, кодоор тусгай вэб хуудсанд нэвтрэх, хурлын ирцээ бүртгүүлж,

хэлэлцэх асуудлуудтай холбоотой асуулт болон саналаа өгсөн бөгөөд хурлын үеэр хүчингүй саналын хуудас байхгүй байлаа. Цахим саналын систем нь хүний оролцооноос шалтгаалсан алдаа гарах эрсдэлгүй бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журмын дагуу системийн шийдлийг нэвтрүүлсэн байна.” хэмээн онцоллоо.




Бизнесийн үйл ажиллагаа

## Дижитал хөрөнгө оруулалт “ЛэндБонд” хөтөлбөрийн Транч II-ын хүрээнд 3.1 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүллээ

“ЛэндБонд”-ын Транч II-ын анхдагч зах зээлийн арилжаа 2022 оны 03 дугаар сарын 28-ны өдрөөс 03 дугаар сарын 31-ний өдрүүдэд зохион байгуулагдаж нийт 188 хөрөнгө оруулагчдаас 3.1 тэрбум төгрөгийг арилжаа зарлагдсан хугацаанаас өмнө татан төвлөрүүлж, анхдагч зах зээлийн

“ЛэндБонд” Транч II-ийн хүүгийн хэмжээг 15% болгон нэмэгдүүлсэн нь энэ удаагийн Транчийн онцлог байж, олон нийтийн анхаарлыг ихээр татлаа.


“ЛэндМН ББСБ” ХК нь Дижитал хөрөнгө оруулалт “ЛэндБонд” Транч II-ийн анхдагч зах зээлийн



арилжаа амжилттай хаагдлаа.

“ЛэндМН ББСБ” ХК-ийн санал болгосон Дижитал хөрөнгө оруулалт ЛэндБонд нь өрийн хэрэгсэл гаргах хөтөлбөрийн хүрээнд 2 удаагийн Транч-аар нийт 5.6 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлээ.

захиалгыг LendMN аппликэйшнээр дамжуулан авах боломжийг хөрөнгө оруулагчдад олгосноор хөрөнгийн зах зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулагчдыг үнэт цаасны зах зээлийн арилжаанд идэвхтэй оролцох боломжуудыг бий болгосноороо давуу талтай байлаа.



Снукер бильяардын  **Дэлхийн аварга, Азийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох эрхээ авлаа.**

**Б.Билгүүнзаяа**

“ЛэндМН”-ийн тусгай активын хэлтэст авлагын ажилтан, Монголын снукер бильяардын шигшээ багийн тамирчин

Бизнесийн үйл ажиллагаа

## ЛэндМН-ийн “Тусгай Активын хэлтсийн авлагын ажилтан” Б.Билгүүнзаяа Снукер бильяардын Дэлхийн аварга, Азийн аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцлоо.

LendMN-ийн гэр бүлийн эрхэм гишүүн, манай хамт олны чадварлаг, авьяаслаг, эрч хүчтэй охидын төлөөлөл “Тусгай Активын хэлтсийн авлагын ажилтан” Б.Билгүүнзаяа Снукер бильяардын Дэлхийн аварга, Азийн аварга шалгаруулах тэмцээнд эх орноо төлөөлөн амжилттай оролцоод ирлээ.

Б.Билгүүнзаяа маань Снукер бильяардынхаа төрлөөр “Улсын аварга-2021” тэмцээний дэд байр, “Цомын аварга-2021” тэмцээнд 3 дугаар байр, “Чайниз пүүл-2022” бильяардын улсын аварга

шалгаруулах тэмцээнээс 3 дугаар байрын шагнал хүртэж дээрх амжилтуудаараа Монголын снукер бильяардын шигшээ багийн тамирчнаар сонгогдож 2022 оны 03 сарын 01-11 өдрүүдэд Катар улсын Доха хотод зохиогдох Дэлхийн болон Азийн аварга шалгаруулах тэмцээнд Монгол улсаа төлөөлж оролцох эрхээ авсан юм.

Дэлхийн аварга шалгаруулах тэмцээндээ эх орныхоо нэрийг гаргаж амжилттай оролцоод ирсэн Лэндийн гэр бүлийн авьяаслаг гишүүндээ баяр хүргэе.

Бизнесийн үйл ажиллагаа

## Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар зохион байгуулсан “Ногоон санхүүжилт бүс нутгийн чуулган”-д амжилттай оролцлоо.

Монгол улс Тогтвортой хөгжлийн зорилгын хүрээнд Монгол улсын ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” төслийг ЛэндМН дэмжин “Санхүүгийн зохицуулах хороо”-нд мод тарих үүрэг амлалтаа хүргүүлээ. Түүгээр зогсохгүй ЛэндМН нь байгаль орчинд ээлтэй төсөл хөтөлбөр, ногоон санхүүжилтийг дэмжин ажиллахаар боллоо.



#дэргэдчиньбайгаа

Бизнесийн үйл ажиллагаа

## Lendauto Эко автомашины зээлийн үйлчилгээ

LendMN аппликейшнээрээ зээлийн эрхээ тогтоолгоод Эко автомашинууд болох /Toyota Aqua, Prius 30, Prius 40, Prius 41, Sai/ хабрид автомашинуудаа зээлээр авах боломжтой боллоо.

### Давуу тал:

LendMN аппликейшнээр дамжуулан таны зээлийн эрхийг хурдан шуурхай тогтоох бөгөөд хамгийн богино хугацаанд харилцагчдын зээлийн хүсэлтийг Ажлын I өдөрт шийдвэрлэн ажиллаж байна.

### Зээлийн нөхцөл:

- Зээлийн хэмжээ: 20 сая хүртэл
- Урьдчилгаа: 15%
- Хугацаа: 48 сар хүртэл
- Зээлийн хүү: 2.3%-2.6%

(Бид зээлийн хэмжээ үнийн дүнг 30 сая хүртэл нэмэгдүүлэх бонус оноог ашиглах тал дээр судалгаа хийж уян хатан нөхцлийг бүрдүүлэхээр ажиллаж байна.)

Машинтай болох утас: 7707-0101

**lendauto**  
Эко автомашины зээл

- 2.3%-2.6%  
Хүү
- 15%-с дээш  
Урьдчилгаа
- 48  
Сар хүртэл

## Харилцагчийн үйлчилгээ

Харилцагчийн үйлчилгээний төв нь нийт 15 ажилтантайгаар хэрэглэгчдэд шаардлагатай тусламж үйлчилгээг үзүүлэн 2022 оны I улирлын турш нийт 43,194 удаагийн зээлийн үйлчилгээ, аппликейшн ашиглалт болон бусад үйлчилгээний

талаар харилцагчдад тухай бүр нь түргэн шуурхай үйлчилгээг үзүүлж тэдгээрийн 98.7%-д амжилттай үйлчлэн, харилцагчдад тулгарсан асуудлыг бүрэн шийдвэрлэсэн байна.

### Харилцагчийн үйлчилгээ

2022 оны I улиралд хүлээн авсан

**33,266**

Нийт дуудлага

**15**

Хүлээлгийн түвшин

Үйлчилгээ

**98.7%**

амжилттай хүргэсэн

сошиал суваг болон

**9,928**

үйлчилгээний заалаар  
үйлчилсэн



# Санхүүгийн үйл ажиллагаа

2022 оны I улирлын гол үзүүлэлтүүд

Нийт актив

**40.74**

тэрбум төгрөг

Нийт орлого

**3.8**

тэрбум төгрөг

Цэвэр ашиг

**0.93**

тэрбум төгрөг

Цэвэр зээлийн багц

**32.97**

тэрбум төгрөг

## Санхүүгийн байдлын хураангуй тайлан /Аудитлагдаагүй/

2022 оны I улирлын байдлаар компанийн нийт хөрөнгийн хэмжээ 40.74 тэрбум төгрөг байгаагаас цэвэр зээлийн багц 32.97 тэрбум төгрөг, мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө 4.70 тэрбум

төгрөг байна. Түүнчлэн өр төлбөр 21.12 тэрбум төгрөг, өөрийн хөрөнгө 19.62 тэрбум төгрөг байгаагаас хуримтлагдсан ашиг 11.14 тэрбум төгрөг байна.

## Санхүүгийн байдлын тайлан

Хөрөнгө /тэрбум төгрөг/	2021.IV	2022.I /Аудитлагдаагүй/
Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө	4.90	4.70
Зээлийн багц (цэвэр)	32.43	32.97
Бусад хөрөнгө	0.77	1.81
Үндсэн хөрөнгө	0.76	0.82
Биет бус хөрөнгө	0.45	0.44
<b>Нийт хөрөнгө</b>	<b>39.31</b>	<b>40.74</b>

Өр төлбөр болон эздийн өмч /тэрбум төгрөг/	2021.IV	2022.I /Аудитлагдаагүй/
<b>Өр төлбөр</b>	<b>19.49</b>	<b>18.28</b>
Эх үүсвэр	15.07	15.31
Бусад өглөг	1.47	2.97
<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>19.81</b>	<b>22.46</b>
Хувьцаат капитал	8.48	8.48
Хоёрдогч өглөг	2.95	2.85
Хуримтлагдсан ашиг	11.33	11.14
<b>Нийт өр төлбөр болон эздийн өмч</b>	<b>39.31</b>	<b>40.74</b>




## Орлого, үр дүнгийн хураангуй тайлан /Аудитлагдаагүй/


2022 оны I улирлын байдлаар компанийн нийт орлогын хэмжээ 3.8 тэрбум төгрөг, 0.93 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажигласан байна.

Орлого, үр дүнгийн хураангуй тайлан /тэрбум төгрөг/	2021.IV	2022.I /Аудитлагдаагүй/
Нийт орлого	3.80	3.80
Хүүгийн зардал	(0.65)	(0.85)
<b>Цэвэр орлого</b>	<b>3.15</b>	<b>2.95</b>
Зээлийн болзошгүй эрсдэлийн нөөцийн зардал	0.05	(0.35)
<b>Үйл ажиллагааны цэвэр орлого</b>	<b>3.20</b>	<b>2.60</b>
Удирдлагын болон ҮА-ны зардал	(1.87)	(1.55)
<b>Татварын өмнөх ашиг</b>	<b>1.33</b>	<b>1.05</b>
Татварын зардал	(0.14)	(0.12)
<b>Цэвэр ашиг</b>	<b>1.19</b>	<b>0.93</b>


### Шимтгэлийн орлого /тэрбум төгрөг/



### Цэвэр ашиг өссөн дүнгээр /тэрбум төгрөг/



# Эрсдэлийн удирдлага



ЛэндМН ББСБ ХК нь зохицуулагч байгууллагаас гаргасан тогтоол, мэдэгдэл, журмын шинэчлэлийг цаг адалгүй өөрийн үйл ажиллагаанд нийцүүлэн мөрдөн ажиллаж байгаа төдийгүй харилцагчид, хувьцаа эзэмшигчид болон компанид ирээдүйд учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэхийн тулд хариу арга хэмжээг авч хэрэгжүүлж, эрсдэлийн удирдлагын үр дүнтэй нэгдсэн тогтолцоог бүрдүүлж ажилласаар байна. 2022 оны I улиралд Комплаенсийн эрсдэлийн удирдлагын хүрээнд “Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл

ажиллагааны дотоод хяналт болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөр”-ийг шинэчлэн баталлаа. “ЛэндМН ББСБ” ХК зээлийн эрсдэлийн үнэлгээ, зээлийн үнэ цэнийн бууралтыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт-9 (IFRS-9) дагуу тооцдог. Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “ББСБ-ын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-д заасны дагуу 2022 оны I улиралд 1.4 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн нөөц сан байгуулахаар байсан боловч СТОУС-9 (IFRS-9)-ын стандартын дагуу 2.5 тэрбум төгрөгийн

зээлийн эрсдэлийн нөөц санг байгуулсан. Энэ нь Санхүүгийн зохицуулах хорооны дээрх журмаар тооцвол зээлийн эрсдэлийн нөөц санг хангалттай түвшинд буюу нийт чанаргүй зээлийн багцын 109.05%-тай тэнцэх хэмжээнд байгуулжээ. 2022 оны I улиралд Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан ББСБ-ын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж ажилласныг доорх хүснэгтээс харна уу.

## Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд

Харьцаа үзүүлэлтүүд	Байвал зохих	2021.IV	2022.I
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	10%-иас доошгүй	48.60%	46.48%
Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	20%-иас доошгүй	55.50%	53.22%
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа	10%-иас доошгүй	50.30%	48.16%
Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа	8%-иас дээш	29.40%	25.75%
Гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	(+/-40%)	-11.09%	-11.00%
Итгэлцлийн үйлчилгээний өглөг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	80%-иас хэтрэхгүй	33.50%	35.54%
Өрийн бичгийн зохистой харьцаа	50%-иас хэтрэхгүй	32.30%	32.62%

# Компанийн засаглал

“ЛэндМН ББСБ” ХК нь компанийн сайн засаглалын тэргүүн туршлагыг үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлж хувьцаа эзэмшигчдэдээ урт хугацааны үнэ цэнийг бий болгох, нэмэгдүүлэх, компанид итгэх итгэлийг бэхжүүлэн ажиллахыг эрмэлздэг төдийгүй Монгол улсын хууль тогтоомжийг дагаж мөрдөх, ил тод байдлыг хангах, нээлттэй тайлагнал, Төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагын үүрэг хариуцлагыг

дотоод журмаар нарийн нягт зохицуулах зэрэг зарчмуудыг баримталж сайн засаглалын хэм хэмжээ, стандартыг бүрдүүлж ажилладаг.

2022 оны 3 сарын 23 өдөр “Санхүүгийн зохицуулах хороо”-оос шинэчлэн баталсан “Компанийн засаглалын кодекс”-ыг дотоод үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

## Төлөөлөн удирдах зөвлөл

ЛэндМН ББСБ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл 2022 оны I улиралд ээлжит I, ээлжит бус I удаа хуралдав. ТУЗ-өөс гаргасан тогтоолуудаас онцлон дурдвал:

- “Эрнст энд Янг Монголиа Аудит” ХХК-аас компанийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг хүлээн зөвшөөрч, тайланг хангалттай гэж дүгнэсэн ба тус дүгнэлтийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулан шийдвэрлүүлэхээр тогтов.
- Компанийн 2021 оны үйл ажиллагааны цэвэр ашгийн 27.5 хувьтай тэнцэх 1.1 тэрбум төгрөгийг Компанийн хувьцаа эзэмшигчдэд мөнгөн хэлбэрээр хуваарилахаар шийдвэрлэв.
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2022 оны 3 дугаар сарын 26-ны өдөр цахимаар хуралдуулахаар шийдвэрлэж, хурлаар хэлэлцэх асуудал, хурал зохион байгуулах болон тооллогын комиссын бүрэлдэхүүн зэргийг батлав.

## ТУЗ-ийн дэргэдэх засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороо

### ТУЗ-ийн дэргэдэх засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороо

ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороо дараах асуудлыг хэлэлцэн, Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх дүгнэлтийг гаргалаа. Үүнд:

- Гүйцэтгэх удирдлагын саналыг үндэслэн ТУЗ-ийн ердийн 3, хараат бус 2 гишүүнийг улируулан сонгох;
- Компанийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд шинээр нэр дэвшигчдийг сонгох;
- ТУЗ-ийн 2022 оны төсвийг батлуулах.

### ТУЗ-ийн дэргэдэх эрсдэлийн удирдлагын хороо


ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороо дараах асуудлыг хэлэлцэв.

- Компанийн эрсдэлийн тайлан;
- Эх үүсвэрийн тайлан;

### ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо

ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо дараах асуудлыг хэлэлцэн, зарим асуудлыг Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх дүгнэлтийг гаргалаа.

- 2021 оны санхүүгийн тайланд хийсэн хөндлөнгийн аудитын дүгнэлт;
- Дотоод аудитын зөвлөмжийн хэрэгжилтийн нэгтгэл тайлан;
- Дотоод аудиторын 2022 оны ажлын төлөвлөгөө.





**ВЕБСАЙТ:**

[www.lend.mn](http://www.lend.mn)

**УТАС:**

7707-0101

**ИМЭЙЛ:**

[board@lend.mn](mailto:board@lend.mn)